



ОРХОН АЙМАГ
**ЖАРГАЛАНТ СУМЫН УЛААНТОЛГОЙ БАГИЙН ИРГЭДИЙН
НИЙТИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 6 сарын 12 өдөр

Дугаар 25

Жаргалант сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
гаргуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 32 дугаар зүйлийн 32.8.1, Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 заалтыг үндэслэн багийн Иргэдийн нийтийн хурлаас ТОГТООХ нь.

Нэг. Улаантолгой багийн Иргэдийн нийтийн хуралдаанд иргэн Э.Үнэнбаяр нь төмс, хүнсний ногоо тариалах газрын гэрчилгээ гаргуулах хүсэлт ирж Иргэдийн нийтийн хурлын олонхын саналаар дэмжигдсэн тул зөвшөөрсүгэй.

Хоёр. Дээрх иргэний материалыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хавсралтаар хүргүүлж ажиллахыг багийн Засаг дарга /П.Барсболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЦЭРЭНДУЛАМ